



**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 22 өдөр

Дугаар А/194

Улаанбаатар хот

**Дүүргийн аварга шалгаруулах шатрын тэмцээн  
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Монгол Улсын Үндсэн хуулийн өдөр"-ийг угтан дүүргийн аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсугай.

2. Тэмцээн зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, зарцуулагдах хөрөнгийн төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Арга хэмжээнд зарцуулагдах 480.000 (Дөрвөн зуун наян мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 11 дүгээр сарын 25 ны өдрийн  
А.Ц.99 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



## БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ШАТРЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

### НЭГ. ЗОРИЛГО

“Монгол Улсын Үндсэн хууль батлагдсан өдөр”-ийг тохиолдуулан шатрын спортыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, иргэд олон нийтийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, оюуны спортыг таниулахад тэмцээний зорилго оршино.

### ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ БАЙГУУЛЛАГА ХУГАЦАА

2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 10.00 цагт дүүргийн Биеийн тамир, спортын хорооны зааланд зохион байгуулагдана.

Тэмцээнийг зохион байгуулах байгууллага:

- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- Засаг даргын Тамгын газар
- Биеийн тамир, Спортын хороо

### ГУРАВ . ТЭМЦЭЭНИЙ ЯВАГДАХ ЖУРАМ

Тэмцээнд оролцох тамирчдын тооноос хамааран техникийн зөвлөгөөн дээр сонгогдсон шүүгч тэмцээний журмыг танилцуулна.

Цагийн хяналт: Талдаа 60 минут байна.

### ДӨРӨВ: ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 08.00-10.00 цагийн хооронд Биеийн тамир, Спортын хороонд бүртгэж, техникийн зөвлөгөөн зохион байгуулна.

### ТАВ: ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Тэмцээнд 18-аас дээш насны /эрэгтэй, эмэгтэй/ дүүргийн иргэн оролцоно.
- Шатрын спортын цолтой иргэн оролцохгүй.

### ЗУРГАА. ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

Эрэгтэй, эмэгтэй тус бүр

Тэргүүн байр Өргөмжлөл, Медаль, Мөнгөн шагнал

Дэд байр Өргөмжлөл, Медаль, Мөнгөн шагнал

Гутгаар байр Өргөмжлөл, Медаль, Мөнгөн шагнал

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын  
2024 оны 11 дүгээр сарын 22 ны өдрийн  
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ  
ШАТРЫН ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХАД  
ШААРДАГДАХ ХӨРӨНГИЙН ТӨСӨВ

Д/д	Шагнал	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ
<b>Мөнгөн шагнал</b>					
1	1-р байр	ш	2	100,000	200 000
	2-р байр	ш	2	80,000	160 000
	3-р байр	ш	2	60,000	120 000
Нийт					<b>480 000</b>